



ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ 2005 ОНЫГ “БИЧИЛ САНХҮҮ, ЖИЖИГ, ДУНД БИЗНЕСИЙГ ДЭМЖИХ ЖИЛ” БОЛГОН ЗАРЛАХ ТУХАЙ 2004 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр Улаанбаатар хот Дугаар 223 Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь: 1. 2005 оныг “Бичил санхүү, жижиг, дунд бизнесийг дэмжих жил” болгон зарласугай. 2. “Бичил санхүү, жижиг, дунд бизнесийг дэмжих жил”-ийн хүрээнд хийх ажлын төлөвлөгөө, уг ажлыг удирдан зохицуулах үндэсний хорооны бүрэлдэхүүний талаар санал боловсруулж Засгийн газарт оруулахыг Гадаад хэргийн сайд Ц.Мөнх-Оргил, Үйлдвэр, худалдааны сайд С.Батболд, Сангийн сайд Н.Алтанхуяг нарт тус тус даалгасугай. 3. “Бичил санхүү, жижиг, дунд бизнесийг дэмжих жил”-ийн хүрээнд зохиогдох арга хэмжээг дэмжиж ажиллахыг Монгол банкны Ерөнхийлөгч О.Чулуунбатад зөвлөсүгэй. Монгол Улсын Ерөнхий сайд Ц.ЭЛБЭГДОРЖ Гадаад хэргийн сайд Ц.МӨНХ-ОРГИЛ Сангийн сайд Н.АЛТАНХУЯГ